

НҮБ-ын еронхий нарийн бичгийн дарга Пан Ги Мун болоод НҮБ-ын болон АОЛ-ийн тусгай толоологч Лахдар Брахими нар үзэхдээ, Сирийн морголдооний бvх талуудад зэвсэг нийлүүлэх нь тус улсад байдлыг хурцатгахад болон хохирогсдын тоог нэмэгдүүлэхэд хүргэж байна гэв. Ингэхдээ тvшмэдvүд нийлүүлэгч орнуудыг нэрлэсэнгvй. Пан Ги Мун болон Брахими нарын НҮБ-ын ондор албан тушаалтнуудтай хамтран явуулсан даваа гаригийн хуралдаан дээр Сирийн морголдооний хоёр талыг шvүмжлэв гэж дэлхийн ХМХ-вүд уламжилж байна. Уулзалтан дээр тэд Сирийн цус урсгасан дайн нь vргэлжилж байна гэж тэмдэглэж байжээ. Пан Ги Мун болон Брахими нар дэлхийн их гvрнvүд дайныг зогсоох тухай болон морголдооний хоёр талыг яриа хэлэлцээрт хүргэхэд тохиролцож чадсангvй гэж цохон тэмдэглэв. Тvүнчлэн тэд онгорсон 6-р сард баталсан Женевын гэрээний тохиролцооны дагуу Сирийн засгийн эрхийг шилжvүлэх тухай олон улсын нэгдсэн байр суурь vгvй байгаад тvгшиж байгаагаа илэрхийлэв.